

ҮЗЭЛ БОДЛЫН СЭТГҮҮЛ ЗҮЙ

Ч. Чойсамба*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, доктор (PhD), дэд профессор

Түлхүүр үг: үзэл бодол, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх, үзэл бодлоо тулгах, үзэл бодлын сэтгүүл зүй.

Ийм гарчгийг уншсан хүний толгойд элдэв бодол төрж юуны магад. Сүүлийн үед хариуцлагатай сэтгүүл зүй, тодорхой сэтгүүл зүй, бодит сэтгүүл зүй, идэвхтэй сэтгүүл зүй гээд мэдэх, мэдэхгүй хүн ОНМХ-ийн үйл ажиллагааны янз бүрийн чиглэл, урсгалын тухай ярих, бичих болсон. Тэр бүгдийн учир начин олдоогүй байхад бас нэг сэтгүүл зүйг гаргаад ирлээ гэж тээршаах нэгэн ч бий байх.

Гэтэл орчин үеийн Монголын ОНМХ-ийн үйл ажиллагаанд үзэл бодлын сэтгүүл зүй хүч түрэн орж ирээд, түрэмгийлэх, ноёрхох шинжтэй болоод байгаа нь харин ч гарцаагүй үнэн билээ. Энэ тухай дэлгэрүүлэн ярихаас өмнө үзэл бодлын сэтгүүл зүй гэж чухам юуг нэрийдээд байгааг цөөн үгээр тодорхойлъё.

Үзэл бодол бол аливаа юмс үзэгдэл, үйл явдал, хүний тухай тодорхой субьектэд төрсөн төсөөлөл, ойлголт юм. Энэ бол тун ч хийсвэр ухагдахуун билээ. Тухайн субьектээсээ

хамаараад үзэл бодол бүр харилцан адилгүй, тэр ч байтугай эсрэг тэсрэг, бүр антагонист байх нь ч бий. Үзэл бодол тогтвортой бус, ялимгүй гадны нөлөөлөл, хүчин зүйлээс хамаараад огцом өөрчлөгдөх нь байдаг. Сонгуулиар түүнд л саналаа өгнө гэж урт удаан хугацааны турш бодож явсан нэгэн чухам санал өгөх тэрхүү эгшинд бодлоо гэнэт өөрчилж, огт өөр нэр дэвшигчийг дэмжих тохиолдол гардгийг алийг тэр гэхэв.

Эрүүл ухамсартай хүн бүр өөрийн гэсэн үзэл бодолтой байдаг. Энэ нь ч зүй ёсны хэрэг. Өөрийн үзэл бодлыг илэрхийлэх эрхийн төлөө хүн төрөлхтөн үеийн үед тэмцсээр ирсэн түүхтэй. Энэ тэмцэл урт бөгөөд ярвигтай замыг туулсан юм. Үзэл бодлоо илэрхийлснээр эрхтэн дархтнуудад элдвээр адлагдах, хавчлага хардлагад өртөх, ардын дайсан «цол» хүртэж, үүний бүх үр дагаварыг амсах, эрх чөлөөгөө хасуулах, цаашлаад амь насаа ч алдах явдал хэчнээн ч гарсныг хэн ч тоолж үл мэднэ. Гагцхүү нэг л үнэнийг бид мэднэ. Өдгөө олон орны иргэд үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх Үндсэн хуулиар олгогдсон эрхээр хангагдсан, түүнийгээ эдэлж байна. Ийм орнуудын нэг нь яах аргагүй

Монгол Улс билээ. 1992 онд батлагдсан Үндсэн хуулийн 2-ын 16-д Монгол Улсын иргэн «итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй» гэж заасан байдаг. Гэтэл ердөө саяхан бид үзэл бодлоо илэрхийлэх нь байтугай, ийм «тансаг өмч»-тэй байхаас ч айдаг, эмээдэг, «гэрэлд цохиулах»-аас болгоомжилдог байлаа.

Сэтгүүлч нь иргэн бүрийн адил үзэл бодолтой байх эрхтэй. Жирийн иргэнийг бодвол тэрхүү үзэл бодлоо илэрхийлэх боломж, эрхээр сэтгүүлч хүн харин ч илүүтэй хангагдсан байдаг. Нийгмийн хөгжлийн

тэргүүн фронт дээр байлдахаа байг гэхэд тэргүүн эгнээнд нь жагсаж байх ёстой сэтгүүлч үзэл бодлоо илэрхийлж байхад буруу нь ч юу байхав.

Ингээд бодохлоор хүний төрөлх эрхийн нэг болох үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрхийн бодит илрэл болсон үзэл бодлын хэмээгдэх сэтгүүл зүй ардчиллын үр дагавар, зүй ёсны үзэгдэл мэт. Гэтэл харамсалтай нь бас тийм биш ажээ. Энэ тухай өөрийн үзэл бодлыг би та бүхэнтэй хуваалцах гэсэн юм.

Юуны түрүүнд үзэл бодлоо илэрхийлэх, үзэл бодлоо тулгах гэдгийн хооронд улсын хилээс ч чанд зааг тогтоомоор байна. Бусдын үзэл бодлыг хүндэтгэж, өөрийн үзэл бодлыг тэдэнд сонирхуулах маягаар

мэдээлэхийг илэрхийлэх гэнэ. Харин бусдад ямар үзэл бодол байгааг үл тоомсорлож, өөрийн үзэл бодлыг тэдэнд хүчээр нялзаахыг тулгана гэмээр санагдлаа.

Саяхан манай улсад зочилсон ардчиллын өлгий нутаг АНУ-ын ерөнхийлөгч Жорж Буш 1990 оны Монголын ардчилсан хувьсгал коммунист дэглэмийг нурааж, коммунистуудын ноёрхолд цэг тавьсан гэж

хэлсэн үгэндээ онцолсон билээ. Энэ бол Жорж Бушийн үзэл бодол. Тэгвэл Монголд одоо ч гэсэн коммунистууд байгаа, тэд нар бол Ху намынхан гэж манай зарим хэвлэл бичдэг. Энэ ч бас үзэл бодол. Уншигч танд ч бас

«
**Бусдын үзэл бодлыг хүндэтгэж,
өөрийн үзэл бодлыг тэдэнд
сонирхуулах маягаар мэдээлэхийг
илэрхийлэх гэнэ. Харин бусдад
ямар үзэл бодол байгааг үл
тоомсорлож, өөрийн үзэл бодлыг
тэдэнд хүчээр нялзаахыг тулгана
гэмээр санагдлаа.**

»

энэ тал дээр өөрийн гэсэн үзэл бодол бий. Тэгвэл хэн нь үзэл бодлоо илэрхийлсэн, хэн нь тулгасан бэ? Хэрэв ардчиллыг гэрэл гэгээ, коммунист дэглэмийг түнэр харанхуй гэж зүйрлэвэл миний бодлоор Монголд нар аль хэдийнэ манджээ. Тодруулж хэлбэл, МОНГОЛД КОММУНИСТУУД БАЙХГҮЙ. Та өөрөөр бодож байвал таны үзэл бодлыг би хүндэтгэж байна.

Үзэл бодлоо тулгаж буй хүн түүнийгээ бататгах ямар нэг баримт нотолгоо гаргаж ирдэггүй, гагцхүү өөрийн бодлыг бусдын тархи руу хүчээр «экспортлох»-ыг зорилгоо болгодог. Одоо тодорхой жишээ рүү орёе.

Өдөр тутмын нэгэн сонинд: «Хэрэв мафи гэдэг юм бий бол манайд түүний загалмайлсан эцэг нь Ч.Улаан

болчихсон юм биш үү. Олон түмэн минь сэрэмжтэй байгтун»¹ гэж бичжээ. Үзэл бодлоо илэрхийлсэн байна уу, тулгасан байна уу гэдгийг ялгаж салгахын тулд бид үгийн өнгө аясыг мэдрэх хэрэгтэй. Ганц үгийн цаана бүхэл бүтэн ертөнц байдаг. Би уншигчийн анхаарлыг хэрэв мафи гэдэг юм бий бол, болчихсон юм биш үү гэсэн хоёр санаан дээр хандуулмаар байна. Монголд мафи байдаг үгүйг сэтгүүлч юутай ч мэддэггүй болж таарлаа. Тэгвэл өөрийн мэдэхгүй байгаа зүйлд толгойлогч олох, тэгэх тэгэхдээ тун ч итгэлтэй тэр толгойлогч нь болчихсон юм биш үү гэж бичих нь хэр зөв бэ? Энэ нь хэрэв хүн амины хэрэг гарсан бол алуурчин нь тэр гэж бичсэнтэй агаар нэгэн буй заа.

Мөнхүү сонинд «Өндөгний хувьсгал»² гарчигтай өгүүлэл нийтлэгджээ. Үүнээс нэгэн хэсгийг тастан авч сийрүүлбээс: «Эрүүл нийгэм-Иргэний хөдөлгөөн Сүхбаатарын талбайд суулт зарлаад хоёр дахь долоо хоногтоо орж байна. Тэдний өчигдрийн үйлдлийг “өндөгний хувьсгал” гэж нэрлэж болно. Учир нь тэд Төрийн ордны баруун урд жигүүрт байрлах Засгийн газрын хуралдааны танхим, УИХ-ын дарга, дэд дарга нарын өрөөний цонх руу өндөг шидсэн юм. Ийм учраас ингэж нэрлэх нь зөв болов уу гэсэн сэтгэгдэл төрлөө». Сайшаалтай нь сэтгүүлч үзэл бодлоо бичиж байгаагаа нуусангүй. Хувьсгал гэж нийгмийн нэг формацийг нөгөө формациар солихыг хэлдэг. Юм бүхнийг хувьсгал гээд тунхаглаад, зарлаад байж болохгүй. Тэгвэл саяхан болж өнгөрсөн Оюутны эрхийн өдрөөр оюутнууд Төрийн ордны зарим цонхыг

чулуугаар хага цохисон балмад явдлыг «Чулууны хувьсгал» гээд нэрлээдэхвэл ямар вэ? Өндөг шидэхлээр өндөгний хувьсгал, улаан лооль шидэхлээр улаан лоольны хувьсгал болчихгүй. Хувьсгал уу, танхайрал уу гэдгийг уншигч бүр өөрөө өөртөө тунгааг. Юутай ч энэ тал дээр би юу гэж бодож байгааг та мэдэрсэн байх.

Одоо өнөөх коммунистуудын тухай яриандаа эргэж орёе. Ийм нэг хачирхалтай жишээг сонирхье. «Төрийн эргэлтийг большевикууд санасан цагтаа хүссэн аргаараа хийдэг. Ардын хувьсгал 1921 онд ялсан гэж үздэг. Гэвч түүнийг большевикууд хүчээр хийсэн юм билээ. Тэд эцсийн зорилгодоо хүрэхийн тулд цуст яргалал үйлдсэн. Харин сүүлд нь тэр аргаа зөвтгөсөн байдаг»³. Сэтгүүлчийн бичсэнээр бол 1921 онд Ардын хувьсгал ялаагүй болж таарах нь (гэж үздэг). Ямар баримтан дээр тулгуурлаж сэтгүүлч ингэж хэлж байгаа юм бол? Монголын түүхийг цоо шинээр бичихээр санаархсан хэрэг үү? Гэвч түүнийг большевикууд хүчээр хийсэн юм билээ гэсэн өгүүлбэрийг уншихад гайхас төрснийг нуух юун. Юм билээ гэснийг бодвол тэр сэтгүүлч л анх түүхийн үнэн бодит баримтыг гаргаж ирсэн гэлтэй. Тэгээд 1921 оны хувьсгалыг Данзан, Бодоо тэргүүтэн Богд хаан, хар, шар феодалуудтай зөвшилцөөд тайван замаар хийчих боломж байсан хэрэг үү? Сүүлийн жилүүдэд л цус урсгалгүй хувьсгал хийх болсон болохоос биш эрх мэдэлтнүүд хэзээ ч хувьсгалчдад найр тавьж байсан удаа үгүй. 1566 оны Нидерландын хувьсгал, 1640 оны Английн хувьсгал, 1789 оны Францын хувьсгал, 1917 оны Оросын хувьсгалыг

аваад үзье. Сэтгүүлчийн бичсэнээр 2005 оны 7 дугаар сард Ж.Бушийн хэлсэнчлэн 1990 онд арга болсон коммунистууд төрийн эргэлт хийхээр санаархсан ажээ. Өндөг шидэхэд хувьсгал гарчихлаа гэж сэрүүн зүүдэлдэг сэтгүүлчдэд төрийн эргэлт хийх гэлээ гэж бичихэд юу ч байхав дээ.

Хувьсгалын сэдэвтээ дахин эргэн оръё. «Хувьсгал эдүгээ манайд ч гарахыг үгүйсгэхгүй. Учир нь эдүүгээгээс 15 жилийн өмнө яг жинхэнэ утгаар Монголд хувьсгал ялаагүй болов уу. Монголд ганц том намтай байсан, одоо ч байсаар. /.../ Тэгэхлээр /.../ "Эрүүл нийгэм Иргэний хөдөлгөөн"-ий тэмцэл нь дараагийн хувьсгал буюу шар зангиатны хувьсгал байх талтай. /.../ Удахгүй манай улсад болох Ерөнхийлөгчийн сонгуулиар тэдний удирдсан шар зангиатны хувьсгал гарч болохыг ч үгүйсгэхгүй байна»⁴. Юутай ч ганц зүйлийг баттай хэлье. Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр шар зангиатны хувьсгал гараагүй. 1990 онд Монголд ардчилсан хувьсгал ялаагүй гэж боддогоо сэтгүүлч уншигчдад тулгажээ. Ийм дүгнэлт хийхэд суурь судалгаа хэрэгтэй. Тэрнээс биш дурын сэтгүүлч 1921, 1990 онд Монголд хувьсгал ялаагүй, гараагүй, харин өндөг шидсэн, шар зангиа зүүсэн явдал хувьсгал мөн гэх нь хэр эрүүл үзэгдэл вэ? Уншигч бидэнд ийм солиотой хүний үзэл бодол хэрэгтэй гэж үү?

Хувьсгалын асуудлыг орхиж, өөр жишээг сонирхъё. «Н.Энхбаяр Ерөнхийлөгч болчихвол УИХ-ын даргын онгойсон суудал руу шүлс асгаруулан дөхөгсөд энэ хэсэгт [Н.Энхбаярыг Ерөнхийлөгч болгох сонирхолтой бүлэг] багтана. УИХ-ын дэд дарга

Д.Лүндээжанцанд даргынх нь суудал хамгийн ойр харагдаад болдоггүй ээ. Өдрийн бодол, шөнийн зүүд. Н.Энхбаярыг Ерөнхийлөгч болгохын төлөө юугаа ч хайрлахгүй зүтгэх эр хүний дотор бодол энэ эрхэмд бий. Хэрээ мэдэхгүй Д.Идэвхтэн бас санаатай даг аа. С.Төмөр-Очир бүлгийн ахлагч байгаад УИХ-ын дарга болсон, түүнээс дутах юм надад юу байхав гэж биеэ хөөрөгдсөн дэврүү бодолтон. Н.Энхбаяр түүнийг УИХ-ын даргад хэзээ ч санал болгохгүйг мэддэг хэрнээ горьдлого нь тасардаггүй, албан тушаалын амь бөхтэй хорхойтон. /.../ УИХ-ын даргын суудалд болдогсон бол одоо ч гэсэн өөрөө үсэрч очоод суучих бодолтой нэг хөөрхийлөлтэй гишүүн, сайд бий. Ц.Нямдорж гэдгийг уншигчид гадарлаж байгаа биз ээ. Энэ хүн тэр суудал руу хорхойссон баавгай шиг шунан тэмүүлж байгаа. Намын бага хурал дээр санал хураалаа гэхэд ганц хүний санал авч мэдэх. Тэр нь өөрөө өөртөө өгөх санал. /.../ Тэгсэн хэрнээ УИХ-ын даргын суудлыг сэрүүн зүүдлэн, унтах нойроо хасч бодлогошрон суугаа дурны хөрөнгө. Дур эзнээ голдоггүй ээ гэдэг»⁵. Иймэрхүү маягаар сэтгүүлч бусдыг доромжилж, бах таваа хангаж байна. Энэ жишээнд тайлбар илүүц биз. Ингэхэд хүн доромжлох эрхийг сэтгүүлчид хэн олгосон юм бэ?

Манай ХМХ-үүд, нэн ялангуяа өдөр тутмын хэвлэлүүд 2005 оны хаваржигаа авилгын сэдвийг «мөлжсөн». Ёстой хэн дуртай нь юу дуртайгаа бичсэн дээ. Хэрэв та үгүй байлгүй гэж бодож байвал баримт сөхье. «Товчхон хэлэх юм бол Монголд авилгал МАХН гэдэг үг өнөөдөр нэг утгатай ойлгогдох болжээ. Үүнтэй

зэрэгцээд МАХН-ын дарга мөн л авилгалын дарга гэж сонсогдох боллоо»⁶. МАХН гэхээр хэн авлига гэж ойлгоод байгаа юм бэ? Хагархай өндөг харчихаад хувьсгал гарчихлаа гэж сэтгэл гоголздог сэтгүүлчдэд л ингэж ойлгогддог байлгүй. МАХН-ын 150 мянган гишүүн бүр авлига аваад сууж байдаг хэрэг үү? Сэтгүүлч ингэж боддог байж болно. Тэгвэл бодох нэг хэрэг. Хамгийн чухал үүнийгээ батлах хэрэгтэй. Ямар ч баталгаа, судалгаагүйгээр МАХН бол авлига гэж үзэл бодлоо олон мянган уншигчдаа тулгах нь сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйд хэрхэвч нийцэхгүй.

Ер нь Ерөнхий сайдын албан тушаал эзнээ олны анхаарлын төвд хүссэн хүсээгүй оруулдаг «мест» бололтой. Бельги, Нидерланд, Герман зэрэг Европын орнуудад Ерөнхий сайд Ц.Элбэгдорж айлчилсныг «Чингисийн үр сад хоёр дахь удаагаа Европыг донсолгов»⁷, «Чингисийн тухай хар PR үлдсэн Европт Ц.Элбэгдорж цагаан PR хийгээд иржээ»⁸ гэсэн гарчигтайгаар «Өдрийн сонин» мэдээлжээ. Ц.Элбэгдорж Нидерландын хатан хаан Беатрикстай 20 минут уулзах байсан боловч 40 минут уулзсан, Германы канцлер Г.Шрёдер «өмнө нь айлчилсан Монголын хэнтэй ч 15 минутаас дээш уулзаагүй хүн. Энэ удаа [Ц.Элбэгдоржтой] бүтэн гурван цаг боллоо», Ц.Элбэгдоржийг хүлээн авахад Шаумбургийн ордны өмнө 39 жилийн дараа анх удаа хүндэт харуул

жагссан тухай энэхүү сурвалжлага, тэмдэглэлд өгүүлнэ. Эдгээр баримтыг би үгүйсгэх гээгүй. Гагцхүү яагаад Европыг донсолголоо гэсэн юм бол? Тэгээд ч Европыг донсолгож чадах хүн энэ ертөнц дээр байдаг юм бол уу? Ерөнхий сайд Ц.Элбэгдоржийн айчлалын ач холбогдлыг би үгүйсгэх гээгүй. Гагцхүү энэ айчлалаас өмнө европчууд монголчуудын тухай, Чингис хааны тухай сөрөг ойлголттой байсан, энэ

айчлалын ачаар л эерэг имиж бүрдсэн мэт бичсэн нь хэт өрөөсгөл болсон байна. Энд нэг ийм өгүүлбэр анхаарал татсан юм: «"Чингис хаан муу хүн байгаагүй, харин тэр үеийн хэвлэл муу байжээ" гэсэн Монгол улсын Ерөнхий сайдын наргиа ч европчуудад ихэд таалагджээ.» Яа-

«
Ерөнхий сайд Ц.Элбэгдоржийн айчлалын ач холбогдлыг би үгүйсгэх гээгүй. Гагцхүү энэ айчлалаас өмнө европчууд монголчуудын тухай, Чингис хааны тухай сөрөг ойлголттой байсан, энэ айчлалын ачаар л эерэг имиж бүрдсэн мэт бичсэн нь хэт өрөөсгөл болсон байна.

»

гаад анхаарал татсан бэ гэвэл дэлхийн анхны хэвлэл 1609 онд гарсан, үүнийг сэтгүүлч мэргэжилтэй Ерөнхий сайд маань мэдэх ёстой. Тиймээс Ерөнхий сайдын ярьсныг сэтгүүлч андуу ташаа ойлгосон бололтой.

Эцэст нь манай өдөр тутмын хэвлэлүүд үзэл бодлоо уншигчдад хэрхэн эрээ цээргүй тулгаж байгааг дараах хүснэгтээр харуулъя. Судалгаанд «Өдрийн сонин», «Өнөөдөр», «Монголын мэдээ» сонины 2005 оны 8 дугаар сарын 3-9-ний дугааруудад Ерөнхий сайд Ц.Элбэгдорж УИХ-ын 65 дугаар тойргийн нөхөн сонгуулиас нэрээ татаж авсныг хэрхэн мэдээлж байсныг жишээ баримттай өгүүлье.

	«Өдрийн сонин»	«Онөөдөр»	«Монголын мэдээ»
1.	Ц.Элбэгдорж улс орны эрх ашгийг урьтал болгон нэрээ татлаа (Гарчиг, 2005.08.03.)	[АН-ын ҮЗХ-ын ээлжит бус хурал дээр] Ц.Элбэгдоржийг «иргэний зориг» гаргалаа гээд дэмжих байдалтай хүн их цөөхөн байх шиг санагдаж байв. «Ганц тойргийн үнээр намаа булшиллаа» гэх үг ч дуулдав. (АН-ынхан сэтгэл дундуур байна. 2005.08.04.)	АН-аас сүр дуулиантайгаар нэрээ дэвшүүлээд тун арчаагүйгээр нэрээ татан түмний шившиг болоод байгаа Ерөнхий Ц.Элбэгдорж өчигдөр болсон ҮЗХ-ныхоо хурал дээр орж ирэн нэрээ татахаар болсноо албан ёсоор дуулгасан байна. (Ц.Элбэгдоржийг журмын нөхөд нь ганц нүдээрээ ч харсангүй. 2005.08.04.)
2.	УИХ-ын 65 дугаар тойргийн нөхөн сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшсэн Монгол Улсын Ерөнхий сайд Ц.Элбэгдорж улс орныхоо эрх ашгийг намынхаа болон хувийн эрх ашгаас дээгүүр тавьж чаддаг болохоо нотлон харууллаа. (Ц.Элбэгдорж нэрээ татсан шалтгаанаа намын нөхөдөө тайлбарлав. 2005.08.04.)	Юутай ч Ц.Элбэгдорж олон хүний шал өөр шийдвэр гаргах байсан нөхцөл байдалд гал байсан нөхцөл байдалд Засгийн унтраагаар ажиллан Засгийн газраа нэг хэсэгтээ авч үлдсэн нь тодорхой болов. /.../ Ерөнхий сайдынх нь хувьд түүний гаргасан энэ шийдвэрийг буруутгах аргагүй боловч улс төрч Ц.Элбэгдоржийн рейтинг эрс унасан гэдгийг хэлэх нь зөв биз. (Ц.Элбэгдорж яагаад нэрээ татсан бэ? 2005.08.04.)	Ерөнхий сайдын суудлаас сална гэхээс Ц.Элбэгдорж үхтлээ айж, шившигтэйгээр нэр дэвшигчийн үнэмлэхээ буцааж өглөө. Ерөнхий сайдаас огцорсноос 65 дугаар тойргийг нь өгчихье гэж. (АН, МАХН орон гарсан тойргуудыг хувааж авч байхаар гэрээ байгуулжээ. 2005.08.04.)
3.	«Ц.Элбэгдорж нэрээ татсанаар намын рейтинг унах уу» гэсэн асуултад намын дарга Р.Гончигдорж хариулахдаа: «Ц.Элбэгдоржийн энэ алхам манай намын рейтингэд эерэгээр нөлөөлнө гэдэгт эргэлзэхгүй байна. Хариуцлага хүлээсэн намын хувьд ард түмнийхээ эрх ашгийг намаас дээгүүр тавьж чадаж байгаа нь АН-д хамгийн том үнэлгээ болно /.../» гэв. Түүний үг хоосон найдвар биш ээ. (Ц.Элбэгдорж яагаад нэр дэвшив, бас нэрээ татав? 2005.08.05.)	/.../ Ерөнхий сайд өөрөө болохоор «нэг тойрог дахь өрсөлдөөнөөс улс орны хэмжээний тогтвортой байдал, Засгийн газрын хөтөлбөр, бодлогыг хэрэгжүүлэхийг илүүд «үзсэн» гэдэг. /.../ Ц.Элбэгдорж нөхөн сонгуульд нэрээ дэвшүүлэхээ больж байж Засгийн газраа аварч үлдэв. Ингэснээр өөрийгөө ч, намынхаа ч нэр хүндийг өөд нь татаагүй. /.../ Гэхдээ аварсан Засгийн газар нь хэр урт настайв гэдгийг хэлэхэд төвөгтэй. (Ширээ бороо зогсч, ширвээтсэн төр тогтож үлдсэн ч... 2005.08.05.)	/.../ Ер нь бол Монголын төрөөр ноён Ц.Элбэгдорж хангалттай тоглосон доо. Тэрбээр нөхөн сонгуулиас нэрээ татах болсон шалтгаанаа тайлбарлахдаа, надаас болоод 76 тойрог дээр бужигнаан үүсэх гэнэ. Үгүй, ингэхэд яахаараа Ц.Элбэгдээг Улаанбаатарын 65 дугаар тойрог дээр нэрээ дэвшүүлэхээр Б.Жаргалсайханы ялалт байгуулсан Сонгинохайрхан дүүргийнхэн, Б.Эрдэнэбатын сонгогдсон Хөвсгөлийн ард түмэн бужигнадаг байна аа. /.../ Мөн түүнийг л огцрохоор яагаад хүүхдийн 3000 төгрөг, хөгшдийн тэтгэвэр оргүй устаж, ядуусын аяга огтхон ч хоолгүй болох гээд байгаа юм бол? («Ам» сайд, «нам» ерөнхийлөгч. 2005.08.05.)
4.	Ерөнхий сайд нөхөн сонгуулиас албан ёсоор нэрээ татаж, МАХН, АН-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулж гарын үсгээ зурцаалаа. Ингэснээр намууд зөвшилцөлд хүрч Төр, засаг тогтвортой ажиллах боломжтой болсон. Хамтарсан Засгийн газрын хэрэгжүүлж эхлээд буй улс орны хөгжил дэвшилд жинтэй хувь нэмэр оруулах томоохон хөтөлбөрүүд үргэлжлэн хэрэгжихээр боллоо. (УИХ албан ёсны хоёр бүлэгтэй боллоо. 2005.08.05.)	Ц.Элбэгдорж: Учраа бөх чинь цэнгэлдэхийг шатаана гээд тойрч гүйгээд байвал яах вэ? (Гарчиг, 2005.08.06.)	Ц.Элбэгдоржийн Ерөнхий сайдаараа үлдэх гэсэн албан тушаалын өчүүхэн сонирхол АН-ыг 65 дугаар тойрогт нэр дэвшигчгүй болгосон. («Тэлээ 25»-ыг өөрсдийнх нь хашаанд хашиж авлаа. 2005.08.05.)

5.	Ерөнхий сайд төр тогтворжсоныг илтгэв (Гарчиг, 2005.08.06.)	Ноён Ц.Элбэгдорж ч урьдын адил бодож түдэлгүй буулт хийв. Ингэхдээ тэрбээр 65 дугаар тойрогт нэрээ дэвшүүлсэн нь улс төрийн талаасаа буруу алхам байсныг онцлон тайлбарласан. Ийнхүү ноён Ерөнхий сайд алдаагаа залруулж, тус тойргоос нэрээ татсанаар Засгийн газар суудалдаа үлдэж, АН нэр дэвшигчгүй хоцров. (Ц.Элбэгдорж «хувирав». 2005.08.06.)	Ерөнхий сайд Ц.Элбэгдорж /.../ нэлээд бухимдуу, хэн нэгэнд гомдоод ч байгаа юм шиг, ууртай ч юм шиг харагдана лээ. «/.../ Зарим сайн талын мэдээллийг өгч бай л даа, та нар» гэж сэтгүүлчдийг «зандрав». Бас «Та нар ард түмэнд юу болсныг хэл /.../» гэж «тушаасан». (Ерөнхий сайд сэтгүүлчдийг «зэмлэв». 2005.08.06.)
6.	[Ц.Элбэгдорж] Учраа бөх нь цэнгэлдэхээ шатаана гэж бодитой заналхийлснээс болоод нэг бөхийг хаяж, цэнгэлдэхээ шатаалгах уу, буулт хийж, галын аюулаас урьдчилан сэргийлэх үү гэсэн хоёр сонголтын удаахыг нь сонгосон бололтой юм. (МАХН, АН үг хэлээ ололцож, АН экс эвслийн орон зайг дангаар эзэгнэлээ. 2005.08.08.)	Айдаст автсан Ерөнхий сайд суудлаа баттай хадгалахын тулд МАХН-аас ам өчгийг авсан нь /.../ хамтын ажиллагааны гэрээ байв. (МАХН-ын дарга юу хэлчихэв? 2005.08.08.)	Уг нь зүрх зоригтой «алтан хараацайнуудын» нэг хэмээн зүй ёсоор тооцогддог байсан Ц.Элбэгдорж сүүлийн үед нүдний шил зүүсэн оцон шувуу шиг арчаагүй нэгэн болсон гэж журмын нөхөд нь шоолон инээлдэх боллоо. («Оцон шувуу» болсоон. 2005.08.06.)
7.	[Ц.Элбэгдорж] «/.../ Хамтарсан Засгийн газар өмнөхөөсөө илүү баталгаатай зөвшилцөлд тулгуурлах боллоо» гэж хэлэв. Үнэхээр ч ойрмогхон Монгол Улсын зээлжих зэрэглэл дээшилсэн бөгөөд ингэснээр манай орон гадаадаас зээл, хөрөнгө оруулалт олж авах хангалттай боломж нээгдэж байгаа юм. (Ц.Элбэгдорж 65 дугаар тойргийн сонгогчидтой уулзав. 2005.08.08.)		Ерөнхий сайд Ц.Элбэгдорж ширээнээсээ холбирохын даваан дээр 65 дугаар тойргийн нөхөн сонгуулиас нэрээ [татав]. Тэрбээр, «Миний ажлыг авах гэсэн хүн 18 хутгалуулаад алуулчихдаг юм шүү» гэдгийг ах намынхандаа битүүхэн сануулж. (Ц.Элбэгдоржийн «шантааж». 2005.08.06.)
8.			[Ц.Элбэгдорж] ард түмний хүн биш, улстөрийн намуудын «хүүхэлдэй» болох замыг сонгов. /.../ [Ц.Элбэгдорж нэрээ татсаных нь шалтгаан бол] ердөө л Ерөнхий сайдынх нь суудал. (Баяртай, Ц.Элбэгдорж! 2005.08.06.)
9.			«Муу дээр муухай, муухай дээр улцан» гэгчээр Ерөнхий Сайд Ц.Элбэгдорж нөхөн сонгуульд нэр дэвшиж шуугиулснаа шившигтэйгээр нэрээ татчихлаа. (Дампуурал. 2005.08.09.)

Энэ асуудал дээр «Өнөөдөр» төвийг сахиж байхад (баримтын сэтгүүл зүй) «Өдрийн сонин», «Монголын мэдээ» хоёр үзэл бодолдоо ороогдож, хэт нэг талыг барьсан нь (үзэл бодлын

сэтгүүл зүй) илэрхий харагдаж байна. Ерөнхий сайд рүү эрээ цээргүй дайрсныхаа төлөө «Монголын мэдээ» багагүй зэмлэл хүртсэнийг уншигч авхай санаж буй биз.

Энэ бүхний төгсгөлд ганц зүйлийг онцолж хэлье. Надад тулах цэг өгөөч, би дэлхийг эргүүлье гэж суут Архимед хэлсэн. Тэгвэл жирийн уншигч миний бие: «Сэтгүүлч та надад баримтыг л мэдээлээч, эргэцүүлэн бодож, үнэлж дүгнэхийг нь би хийе» гэмээр байна.

Ишлэл

1. С а м д а н Д. Ерөнхий сайд шийдвэр дээрээ зогсох хэрэгтэй байна. ӨС, 2005.07.01.
2. Э р д э н э б а т Г. Өндөгний хувьсгал. ӨС. 2005.04.28.
3. Д а ш р э н ц э н Г. Монголын ортодокс коммунистуудын төрийн эргэлт хийх гэсэн санаархал таслагдлаа. ӨС, 2005.07.28.
4. Б а т б а а т а р М. Шар зангиатны хувьсгал гарч магадгүй. ӨС, 2005.04.13.
5. Ц о г т б а а т а р Х. МАХН Н.Энхбаярыг юуны учир нэр дэвшүүлэв?! ӨС, 2005.05.06.

6. Э р д э н э б а т Г. МАХН авилгал, МАХН-ын дарга авилгалын дарга гэж сонсогдох боллоо. ӨС, 2005.05.02.
7. ӨС, 2005.06.20.
8. ӨС, 2005.06.21.

Резюме

В данной статье автор, опираясь на свои исследования и наблюдения, выдвигает версию о т. н. журналистике мнений. Особенности и сущность такой журналистики заключаются в том, что журналист в ультимативной форме предлагает своё мнение аудитории, не подтверждая его фактами. Чаще всего это «мнение» является попросту высосанным из пальца и представляет собой форму манипуляции сознания масс.